



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1172

Номгон

“Усны сан бүхий газар, ус хангамжийн эх
үүсвэрийн хамгаалалтын бүс тогтоох
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/7 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.2.2, 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.


1. Аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн ба хязгаарлалтын бүсийн талбайн хэмжээ, хилийн заагийг сум тус бүрээр тогтоон зураглал боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Усны сан бүхий газар, унд ахуй ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тогтооход шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Хамгаалалтын бүсийн хил заагийг сум тус бүрээр тогтоож, баталгаажуулан ажлын хэсгийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Ням-Очир)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310155

Аймгийн Засаг даргын 2023 оны 4 дугаар сарын 22-
ны өдрийн 2023/4 дугаар захирамжийн хавсралт



**УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
БҮС ТОГТООЖ, ЗУРАГЖУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ням-Очир (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга)

Гишүүд:

Б.Зүгдоржав (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ш.Бат-Очир (БОНСГЗ-ны нуурын экосистемийн үнэлгээ, судалгаа
шинжилгээ хариуцсан мэргэжилтэн)

М.Дүүрэн (БОНСГЗ-ны Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээ
хариуцсан мэргэжилтэн)

Т.Ариунзаяа (БОНСГЗ-ны Газарзүйн мэдээлэл, усны мэдээллийн
дэд сан хариуцсан мэргэжилтэн)

Сумын Засаг дарга нар

Сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Газрын даамал, байгаль
хамгаалагч

Нарийн бичгийн дарга:

Г.Нансалмаа (БОНСГЗ-ны Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээ
хариуцсан ахлах мэргэжилтэн)

_____оОо_____